

**Эрдмийн зөвлөлийн 2010 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн
хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулав.**

ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН БАГШ СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВАХ ЖУРАМ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ, ЗОРИЛГО

ХИС-ийн багшийн албан тушаалд хүмүүсийг сонгон шалгаруулж ажиллуулах, багшийн мэргэжлийн ур чадварт тавих нийтлэг шаардлага, тэднийг чадваржуулж, хөгжүүлэх үйл ажиллагааг “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “ХИС-ийн Дүрэм”, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын заалтуудад нийцүүлэн зохион байгуулахад энэхүү журмын зорилго оршино.

Нэг. ХИС-ийн БАГШИД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА.

- 1.1. ХИС-ийн багш нь тухайн мэргэжлээрээ онол, практикийн гүнзгий мэдлэгтэй, сургалт, эрдэм шинжилгээний ажлыг хослуулан гүйцэтгэх дадал, чадвартай, математик мэдлэг өндөртэй, сургах, хүмүүжүүлэх арга зүй эзэмшсэн, багшлах сонирхолтой өөрийгөө байнга хөгжүүлэхийн төлөө санаачилгатай ажилладаг, англи хэлээр мэргэжлийн хичээлээ заах чадвартай, сурган хүмүүжүүлэгч-эрдэмтэн хүн байна.
- 1.2. ХИС-ийн багшийн албан тушаал нь:
 - Профессор
 - Дэд профессор
 - Багш
 - Туслах багш /дадлагажигч багш/ гэсэн шатлалтай байна.
- 1.3. ХИС-ийн багш нь заах хичээлийн чиглэлээрээ суурь дээд боловсрол эзэмшсэн, магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна.
- 1.4. Багшийн албан тушаалд томилогдсоноос хойш 2 жилийн дотор их, дээд сургуульд “Багшлах эрхийн үнэмлэх” авсан байна.
- 1.5. Багшийн сонгон шалгаруулалтыг Ректорын ажлын алба, Салбар сургууль, харьяа тэнхим хамтран зохион байгуулна.
- 1.6. Багшийг хөгжүүлэх асуудлыг сургалт, эрдэм шинжилгээний үндсэн нэгж болох харьяа тэнхим, салбар сургууль хариуцна.
- 1.7. Шинээр багш авах асуудлыг тухайн хичээлийн жилийн 09 ба 01 дүгээр сард багтаан нэгдсэн журмаар зохион байгуулж шийдвэрлэнэ. Хичээлийн жилийн улирлын дундуур шинээр багш авах зайлшгүй шаардлага гарвал зөвхөн захирлын зөвшөөрлөөр энэхүү журмын дагуу шийдвэрлэж байна.
- 1.8. Салбар сургуулийн багшид тавигдах шаардлага

- 1.8.1. ХИС-н Бизнесийн сургууль, Мэдээлэл, харилцааны менежментийн сургууль, Олонулсынхарилцаа, нийгэмсудлалынсургуульд багшаар ажилд орсоноос хойш 2 жилийн дотор судалгааны чиглэлээ батлуулсан байна.
- 1.8.2. ХИС-ийн Бизнесийн сургууль, Мэдээлэл, харилцааны менежментийн сургууль, Олонулсынхарилцаа, нийгэмсудлалынсургуулийн дэд профессор багш, профессор багш нь мэргэжлийн хичээлээ англи хэл дээр явуулах бөгөөд бэлтгэлийг бүрэн хангасан байна.
- 1.8.3. ХИС-ийн ХСС-ийн тухайн хэлний багш нь зааж буй хэлний төвшингөөрөө олон улсын зэрэглэлтэй байна.

Хоёр. ХИС-ийн БАГШИЙН АЛБАН ТУШААЛД СОНГОН ШАЛГАРУУЛЖ, АЖИЛЛУУЛАХ

- 2.1. ХИС-ийн багшийн сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:
- 2.1.1. Тус их сургуульд багшилж байгаад гадаад, дотоодын докторантурт суралцаж, эрдмийн зэргээ амжилттай хамгаалсан эрдэмтдийг шалгалтгүйгээр багшийн албан тушаалд томилон ажиллуулна.
- 2.1.2. Их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагад үр бүтээлтэй ажиллаж байгаа багшлах сонирхолтой, өндөр мэргэшлийн эрдэмтдийг урьж ажиллуулна.
- 2.1.3. Багшийн албан тушаалд тавих шаардлагад нийцүүлэн уралдаант шалгаруулалтаар өрсөлдүүлж авна.
- 2.1.4. Сонгон шалгаруулалтыг захирлын тушаалаар байгуулагдсан “Багш сонгон шалгаруулах ажлын хэсэг” их сургуулийн хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулна.
- 2.1.5. ”Багш сонгон шалгаруулах ажлын хэсэг” нь сонгон шалгаруултанд орохоор бүртгүүлсэн бүх хүмүүстэй ярилцлага хийнэ.
- 2.1.6. Уралдаант шалгаруулалтанд орж буй хүмүүсээс:
- мэргэжлийн бэлтгэл, ур чадвар
 - гадаад хэлний мэдлэг /IELTS, TOEFL–ийн шалгалт/
 - компьютер ашиглах чадвар гэсэн чиглэлээр тус тус дэд комиссууд шалгалт авна.
 - Шаардлагатай гэж үзвэл хичээл заалгаж, багшлах ур чадварт үнэлгээ өгч болно.
- 2.1.7. Шинээр авах багшийн хэрэгцээг тодорхойлохдоо орон тоо, заах хичээл, судалгаа шинжилгээний ажлын чиглэл, сургалтын цагийн ачаалал /3-аас доошгүй жил тогтвортой ачаалалтай байх/ бүхий мэдээллийг холбогдох тэнхим гаргаж, сургуулийнхаа Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлсэн саналаа тухайн оны 06, 12 дугаар саруудад хүнийнөөцийналба (ХНА)-д ирүүлнэ.
- 2.1.8. “Дээд боловсролын тухай хууль”-ийн дагуу багшид тавих үндсэн шаардлагаас гадна тухайн хичээлийг заах багшийн “Албан тушаалын тодорхойлолт”-ыг ХНА-наас нарийвчлан гаргаж, тусгай шаардлагыг тодорхойлсон байна.

- 2.1.9. Сонгон шалгаруулалтанд орох хүмүүс дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
- Төрийн албан хаагчийн биеийн байцаалт /анкет/-ыг зааврын дагуу бүрэн бөглөсөн
 - Мэргэжлийн боловсролын бакалавр, магистр, докторын зэргийн диплом, эрдмийн цолны үнэмлэх, IELTS, TOEFL-ийн оноо тэдгээрийн нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт
 - Бүтээлийн жагсаалт /дэлгэрэнгүй/
 - Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
 - 3x4 хэмжээтэй 2 хувь зураг
- 2.1.10. Уралдаант шалгаруулалтанд бакалаврын зэргийн дипломын голч дүн 2.5-аас, магистрынх 3.0-аас доошгүй үнэлгээтэй хүмүүсийг бүртгэнэ. Шалгалтын үнэлгээний систем нь өөр үнэлгээтэй гадаад, дотоодын их дээд сургуулийн дипломтой бол голч дүнг ХИС-ийн Сургалт, судалгааныхөгжил, аудитынүйлчилгээний алба (ССХАҮА)-аар дүйцүүлж тооцуулсон байна.
- 2.1.11. Багш сонгон шалгаруулах тухай зарыг шалгалт эхлэх өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлаж мэдэгдэнэ.
- 2.1.12. Мэргэжлийн шалгалтанд “В”-ээс доошгүй үнэлгээ авсан хүмүүсийг гадаад хэлний мэдлэг, компьютер ашиглах чадварын шалгалтанд оруулах бөгөөд энэ 2 шалгалтанд тус бүрд нь авбал зохих онооны 70-аас доошгүй хувийг авсан нөхцөлд тэнцсэнд тооцно.
- 2.1.13. Докторын зэрэг, эрдмийн цолтой хүмүүстэй мэргэжлийн шалгалтын комисс ярилцлага хийж, үнэлгээ өгөх ба докторын зэрэгтэй хүмүүсээс TOEFL-ийн шалгалт авч 70 хувиас дээш амжилт үзүүлсэн тохиолдолд компьютер ашиглах чадварын шалгалтанд оруулах бөгөөд шалгалтанд 70-аас доошгүй оноо авсан тохиолдолд тэнцүүлнэ.
- 2.1.14. Энэ журмын 2.1.12, 2.1.13-д заасан болзлыг хангаж, сонгон шалгаруулалтанд тэнцсэн хүмүүсийг багшийн ямар албан тушаалд ажиллуулах тухай харьяа тэнхимийн саналыг ХИС-н Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, түүний шийдвэрийг үндэслэн захирлын тушаалаар багшийн албан тушаалд томилно.
- 2.1.15. Шинээр ажилд орж байгаа багштай ХИС-ийн захирал “Хөдөлмөрийн гэрээ”-г байгуулж, цаашид ажлын үр дүнг харгалзан сунгах, цуцлах асуудлыг “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн зохих заалтын дагуу шийдвэрлэж байна.

Гурав. БАГШИЙН МЭРГЭЖЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ

- 3.1. Шинээр ажилд орсон багш эхний 5 жилд өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж, хичээлийн жилийн улирал тутам нэгээс доошгүй удаа нээлттэй хичээл явуулж, үнэлүүлсэн байхаас гадна сургалт, эрдэм шинжилгээний ажлын тайланг хичээлийн жил бүр харьяа тэнхимийн хурлаар хэлэлцүүлэн дүгнүүлсэн байна.

Туслах багш нь эрдэм шинжилгээний ажлын чиглэлээ сонгож, судалгааны ажлаа эхэлсэн байна.

3.2. Багшид мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд дараах хэлбэрээр сургуулийн зүгээс дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

- Гадаад, дотоодод докторантурт суралцах;
- Мэргэжлийн чиглэлээр гадаад, дотоодод богино хугацаагаар сургалтанд хамрагдах;
- Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх, багшлах эрхийн үнэмлэх олгох сургалтад хамрагдах;
- Боловсруулж, туурвисан бүтээлийг хэвлүүлэн нийтлүүлэх;
- Эрдэм шинжилгээний төсөвт болон аж ахуйн гэрээт ажил гүйцэтгэх, олон улсын төсөлд оролцож ажиллах;
- Бүтээлийн чөлөө авах;
- Бизнесийн байгууллагуудад мэргэжлийн зөвлөхөөр ажиллах;